



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/2019

Чингис хот

Гамшгаас хамгаалах команд штабын цахим
сургуулийн бэлтгэл хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Улсын онцгой комиссын А558 дугаар албан үүргийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Онцгой комиссоос “Коронавирусийн халдвар /Ковид-19/-т цар тахлын үеийн харилцан ажиллагаа хариу арга хэмжээ” сэдэвт дадлага сургуулийг цахимаар зохион байгуулахтай холбогдуулан “Гамшгаас хамгаалах команд штабын цахим сургууль”-ийг 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулсугай.


2. Сургуулийн бэлтгэлийг хангуулахад шаардлагатай зардлыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2, 51.3-т заасны дагуу санхүүжилтийг бүрдүүлж захиран зарцуулахыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай.

3. “Коронавирусийн халдвар /Ковид-19/-т цар тахлын үеийн харилцан ажиллагаа хариу арга хэмжээний төлөвлөгөө, дайчилгааны төлөвлөгөөнд тодотгол хийж, бүх төрлийн нөөцийн судалгааг шинэчлэн цахим сан бүрдүүлж, шуурхай штабуудыг цахимаар холбох бэлтгэл ажлыг ханган ажиллахыг Онцгой комисс, гамшгаас хамгаалах мэргэжлийн албад, мэргэжлийн анги, сумдын Засаг дарга, байгууллага аж ахуйн нэгжийн дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

4. Сургуультай холбогдуулан бусад төлөвлөгдсөн үйл ажиллагааг хойшлуулах, хүндэтгэх шалтгаангүй сургуулийн нэгдсэн сургалт, дадлага тасалсан албан хаагчдад холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

5. Онцгой комисс, гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн анги, сумдын Засаг дарга, байгууллага аж ахуйн нэгжийн дарга, удирдах бүрэлдэхүүнийг сургуульд бүрэн хамруулах, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж удирдлагаар ханган ажиллахыг ажлын хэсгийн ахлагч аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА